МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ИРГЭНИЙ ХЭРГИЙН ТАНХИМД

Хяналтын журмаар гомдол гаргах тухай.

Бөгөө овогт Иш-Гомбын Дорж би хариуцагч Д.Бат-Өлзий, Ё.Ариунзаяа нарт холбогдох "61.000.000 төгрөг гаргуулах тухай" нэхэмжлэлийн шаардлага бүхий иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2026 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 210/МА2026/01399 дугаартай магадлалыг 2026 оны 07 дугаар сарын 20-ний өдөр гардан авч танилцаад дараах үндэслэлээр эс зөвшөөрч энэхүү хяналтын шатны гомдлыг гаргаж байгаа болно. Үүнд:

1. Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2 дахь хэсэгт зааснаар тус хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь харьцуулан үзэж, хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөв талаас нь үнэлээгүй, хуулийг зөрүүтэй талбарлан хэрэглэсэн гэж үзэж байна.

Учир нь Давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 243 дугаар дугаар зүйлийн 243.1-д заасан "Худалдах худалдан авах гэрээ"-ний агуулгыг бодитой үнэлээгүй, тус хуулийн 252 дугаар зүйлийн 252.1, 252.2-т заасан эд хөрөнгийн эрхийн доголдолын талаарх ойлголтын эрх зүйн шинжийг зөв тодорхойлоогүй байна.

Тухайлбал:: Тус иргэний хэрэгт авагдсан нотлох баримтаар зохигчдын хооронд эрх шилжүүлэх гэрээний дагуу автомашины үнэ шилжсэн, гэвч тухайн автомашин нь бодит байдалд жинхэнэ өмчлөгч нь өөр буюу эрхийн зөрчилтэй эд хөрөнгө байсны улмаас нэхэмжлэгч тухайн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид нь буцаан өгсөний улмаас зорьсон үр дүнгээ хэрэгжүүлэх зорилго нь биелэгдээгүй, мөн тухайн тээврийн хэрэгсэл нь гуравдагч этгээдийн өмчлөлд хамаарах өмнө нь эрхийн зөрчилтэй эд хөрөнгө байсан болох нь нэхэмжлэгч болон холбогдох гэрч нарын цагдаагийн байгууллагад өгсөн тайлбар, мэдүүлэгээр давхар нотлогдож байгаа, энэхүү нөхцөл байдлыг хариуцагч Д.Бат-Өлзий нь урьд нь мэдэж байсан, нэхэмжлэгчийн зүгээс тухайн үед түүнээс холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг хүссэн боловч тэрээр ямар нэг шийдвэрлэх үйл ажиллагаа авч хэрэгжүүлээгүй нь улмаас арга буюу цагдаагийн байгууллагад хандсан болох нь тус иргэний хэрэгт авагдсан нотлох баримтаар хангалттай тогтоогдож байх боловч энэ талаар давж заалдах шатны шүүхээс анхаарч үзээгүй болно

2. Тус Давж заалдах шатны шүүхээс " ... /5./ хэний гэм буруутай үйлдлийн улмаас автомашин бусдын өмчлөл, эзэмшилд шилжсэн, мөн нэхэмжлэгч нь автомашинтай холбоотой хариуцагч талаас бус яагаад бусдаас мөнгөн хөрөнгө шилжүүлэн авсан зэрэг үйл баримтыг тодруулах,

сэргээн тогтоох ажиллагааг явуулсаны дараа маргааныг шийдвэрлэх нь зүйтэй ...", "... анхан шатны шүүх хэргийн үйл баримтыг бүрэн бодитой тогтоосоны эцэст хэргийг хянан шийдвэрлэх ёстой ..." гэж дүгнэсэн нь хууль зүйн үндэслэлгүй байна.

Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.2-д хэргийн оролцогч нь шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх үүрэгтэй, тус хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч нь өөрийн шаардлага ба татгалзлын үндэс болж байгаа байдлын талаархи нотлох баримтаа өөрөө гаргаж өгөх, цуглуулах үүрэгтэй гэж заасан байх ба хариуцагчийн өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс дээрх үүргээ биелүүлээгүй байгааг Давж заалдах шатны шүүх анхаарч үзээгүй болно.

Нөгөө талаас хариуцагчийн өмгөөлөгч болон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн зүгээс гаргасан гэрч асуулгах, холбогдох нотлох баримтыг гаргуулах хүсэлтийг анхан шатны шүүхээс ханган шийдвэрлэж дахин хүсэлт гаргаагүй тул хэргийг цугларсан нотлох баримт болон нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд талуудыг оролцуулан мэтгэлцэх зарчмыг ханган хянан шийдвэрлэсэн атал давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэлийн хүрээнээс хальсан шийдвэр гаргасан.

Өөрөөр хэлбэл энэхүү нөхцөл байдал нь нэхэмжлэгчийг эрхээ хамгаалах талаар идэвхтэй байсан эсхүл эрхээ хэрэгжүүлэх боломжтой атлаа хэрэгжүүлээгүй гэж үзэх үндэслэлгүй байх бөгөөд хариуцагчийн үүргээ биелүүлээгүй нөхцөл байдлыг магадлал гаргахдаа харгалзан үзээгүй хэт нэг талыг барьсан шийдвэр гаргасан гэж үзэж байна.

Иймд нэхэмжлэгчийн зүгээс тус Давж заалдах шатны шүүхийн магадлалд дурьдсан хууль хэрэглээний зөрүүг арилгах нь цаашид Улсын Дээд шүүхээс хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзэж энэхүү гомдлыг гаргаж байх тул хүлээн авч хянан шийдвэрлэж, тус давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 243.1, 252 дугаар зүйлийн 252.1 болон 252.2 дахь заалтын хүрээнд анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү гэж хүсье.

Гомдолд: Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт 1 хуудас баримт хавсаргав.

Гомдол гаргасан: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 40-р байр, 70 тоот хаягт оршин суугч

...../И.Дорж/

Утас: 99122213. РД: ЧА87071276

2026 оны 08 дугаар сарын 03